



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/686

Мөрөн сум

Төсөвт өртгийн дээд хязгаар
тогтоох тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит III дугаар хуралдааны III/31 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сан дахь “Зураг төсвийн сан”-аас “Сумын төвийг инженерийн шугам сүлжээнд холбох ажлын зураг төсөв боловсруулах” (Тариалан сум) зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг 400,000,000 (Дөрвөн зуун сая) төгрөгөөр баталсугай.

2. Дээрх төсөл, арга хэмжээний зураг төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газар (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

3. Зөвлөх үйлчилгээний зардлыг холбогдох эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус даалгасугай.

4. Төсөл, арга хэмжээний зургийн даалгавар, техникийн нөхцөл, техникийн тодорхойлолт зэрэг холбогдох баримт бичгийг бэлтгэн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Гандэлгэр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712012109